



**МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

Метро бизнес төв, А блок 5 давхар
Д.Сүхбаатарын гудамж-13
Сүхбаатар дүүрэг Улаанбаатар 14201-0033
Утас: 30 42 58, Факс: (976-11) 32 77 20
Цахим хуудас: www.crc.gov.mn
Цахим шуудан: info@crc.gov.mn

2019. 06. 19 № 01/815
танай _____-ны № _____-т

Зөвлөмжийн биелэлт хүргүүлэх тухай

Харилцаа Холбооны Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд ҮАГазар, Монголиан бизнес рейтинг аудит ХХК-с санхүүгийн тайлангийн аудит хийж менежментийн захидлаар нийт дөрвөн зөвлөмжийг хүргүүлсэн.

Тус зөвлөмжийн хүрээнд Харилцаа Холбооны Зохицуулах хороо нь дараах арга хэмжээг авч ажиллаж байна.

Үүнд:

1. Зөвлөмж 1 ажлын хүрээнд:

Нягтлан бодох бүртгэлийн 20-р зүйлийн 20.2.5-р заалтыг хэрэгжүүлж, насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээг авч ажиллах,

1-рт: НББ тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5-р заалт:

Орлого хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгахдаа иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн тус хорооноос зөвшөөрөл олгох шийдвэр гарснаар бүртгэдэг байсныг 2017 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 233 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн Бодлогын баримт бичигт өөрчлөн зааснаар гэрээний нөхцлийг хүлээн зөвшөөрч гэрээнд гарын үсэг зурсан, эхний жилийн төлбөр төлөгдсөн, төлөхөөр хүлээн зөвшөөрсөн, амлалт бичиг ирүүлсэн тохиолдолд бүртгэлжүүлж байгаа нь бодит бус авлага нэмэгдэх эрсдэлийг бууруулсан.

2-рт: Бүртгэгдсэн авлагын үүссэн шалтгаан, нөхцөл байдлыг холбогдох шийдвэр, баримт бичиг, нотлох баримтад үндэслэн зөвшөөрөл бүрээр магадлан шийдвэрлэх зорилго бүхий ажлын хэсэг тус хорооны даргын 2019 оны 4-дүгээр сарын 01-ний өдрийн А/82 тоот тушаалаар батлагдан ажиллаж байна. Уг ажлын хэсэг 2018 оны жилийн эцсийн санхүүгийн

тайланд тусгагдсан 484 иргэн, хуулийн этгээдтэй хамааралтай цуцлагдсан, дууссан төлөвтэй 615 зөвшөөрлийн 1,008.8 сая төгрөгийн үнийн дүн бүхий авлагад үзлэг хийж санал, дүгнэлтээ гарган тус хорооны даргын зөвлөлийн хуралд танилцуулан хэлэлцүүлснээр авлага барагдуулахаар шүүхэд хандах, хууль эрх зүйн зөвлөгөө үзүүлэх аутсорсингийн гэрээг гурван хуулийн фирмтэй байгуулан ажиллаж эхэллээ. 2019 оны 6 дугаар сарын байдлаар нийт 215 тусгай зөвшөөрлийн 1,254.20 сая төгрөгийн авлагыг бүрэн, 11 тусгай зөвшөөрлийн 38,30 сая төгрөгийн авлагыг хэсэгчлэн барагдуулсан байна. Энэхүү ажлын хүрээнд Захиргааны ерөнхий хууль болон бусад холбогдох хууль журмын дагуу өр төлбөр бүхий тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд албан тоот мэдэгдэл хүргүүлэх, сонсгол хийх зэрэг шат дараалсан арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа бөгөөд 2019 оны 6-р сарын Хорооны хуралдаанаар гишүүдэд авлага барагдуулахтай холбоотой ажлын танилцуулга хийж, хугацаа дууссан, өр төлбөрийн үлдэгдэлтэй нийт 90 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлүүллээ.

Жич: Холбогдох баримтыг хавсаргаав.

2. Зөвлөмж 2 ажлын хүрээнд:

Үр дүнгийн урамшуулал олгох заавар, журмыг хууль тогтоомжид нийцүүлж, шинэчилж мөрдөж ажиллах,

ХХЗХорооны ажилтан, албан хаагчдын ажлыг гүйцэтгэлийг үнэлэх, ажлын үр дүнгээр урамшуулал олгох журмыг үр дүнгийн гэрээнд тусгагдсан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн биелэлт, ур чадвар, бүтээлч сэтгэлгээ, байгууллагад оруулсан хувь нэмэр тус бүрээр нарийвчлан дүгнэж тэдний ажлын бүтээмж хариуцлагыг дээшлүүлэх, хөдөлмөрийн сахилга батыг чангатгах, бүтээлч идэвх санаачилгыг өрнүүлж бүтээгдэхүүн нийлүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг амжилттай биелүүлэх зорилготойгоор шинэчлэн боловсруулж тус хорооны даргын зөвлөлийн хурлаар танилцуулан хэлэлцүүлж, Хорооны даргын тушаалаар батлан 2019 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр шийдвэрлэн ажиллаж байна.

3. Зөвлөмж 3 ажлын хүрээнд:

Санхүүгийн программд өөрчлөлт оруулж, ХХЗХорооны гишүүдийн хуралдааны цалин хөлсний зардлыг батлагдсан төсвийн ангиллын дагуу бүртгэж тайлагнах,

ХХЗХорооны хуралдааны гишүүдийн цалин хөлсийг тус хорооны ажилтан албан хаагчдын цалин хөлсний Payroll програмаар тооцон олгож байсан нь санхүүгийн тайланд ажиллагсадтай холбоотой зардлаар илэрхийлэгдсэн бөгөөд 2019 оны 1 дүгээр сараас тооцон бүртгэл, программд өөрчлөлт оруулж, Хорооны хуралдааны үйл ажиллагааны зардлын холбогдох данстай холбон батлагдсан төсвийн ангиллын дагуу бүртгэн олгож байна.

4. Зөвлөмж 4 ажлын хүрээнд:

Хөдөлмөрийн гэрээг цуцлах болон дуусгавар болгохдоо хууль, журамд заасан үндэслэл, шаардлагад нийцүүлэн ажиллаж, дахин давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах,

2019 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн байдлаар тус Хорооны ажилтан албан хаагчдын хөдөлмөрийн гэрээг цуцлах, дуусгавар болгохтой холбоотой аливаа асуудал үүсээгүй бөгөөд бид цаашид холбогдох хууль, журмыг мөрдөн ажиллана.

Хувийг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт,

Монголиан бизнес рейтинг аудит ХХК-д

ДАРГА



Г.ЧИНЗОРИГ



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ

2019 ОА . ОИ

А/82

Ажлын хэсэг байгуулах тухай

Тус хорооны дүр мийн 3.1.1, 3.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хуримтлагдсан авлагад хяналт, үзлэг шинжилгээ хийж; цуцлагдсан, дууссан төлөвтэй зөвшөөрлийн бүртгэгдсэн авлагын үүссэн шалтгаан, нөхцөл байдлыг холбогдох шийдвэр баримт бичиг, материалд нь үндэслэн тогтоож зөвшөөрөл тус бүрээр нь тодорхойлолт хийж, магадлагаа гаргаж шийдвэрлүүлэх ажлын хэсгийг байгуулсугай.
2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Ажлын хэсгийн үйл ажиллагааны тайланг тус Хорооны даргын зөвлөлийг хуралд танилцуулахыг ажлын хэсгийн нарийн бичиг /Д.Гантуяа/-т үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

Харилцаа холбооны зохицуулах хорооны
даргын 2019 оны 04 сарын 01 өдрийн
А/ тоот тушаалын нэгдүгээр хэвсрэлт
182

АВЛАГА БАРАГДУУЛАХ, ШИЙДВЭРЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: З.Эрдэнэчулуун /ЗУХАГ-ын дарга/

Нарийн бичиг: Д.Гантуяа /ЗУХАГ орлого хариуцсан
мэргэжилтэн/

Ажлын хэсгийн гишүүд:

- Ю.Баярбаатар /ДХАА дарга/
- А.Эрдэнэбулаг /ЗУХАГ ЗУХ-ийн дарга/
- Н.Халиунаа /Ерөнхий нягтлан бодогч/
- Ц.Жаргалсайхан /ДХАА дотоод аудитор/
- Ц.Бүрэнжаргал /ЗУХАГ гэрээ, эрхзүйн
мэргэжилтэн/
- Т.Ууганбат /ЗУХАГ гэрээ, эрхзүйн
мэргэжилтэн/
- Э.Эрдэнэбаяр /ЗУХАГ орлого хариуцсан
мэргэжилтэн/
- М.Гантөмөр /ЗУХАГ тусгай зөвшөөрөл
хариуцсан мэргэжилтэн/
- Б.Дэлгэрцэцэг /ЗУХАГ тусгай зөвшөөрөл
хариуцсан мэргэжилтэн/
- Т.Түвшинбаяр /ЗУХАГ Архив, бичиг
хэргийн ажилтан/
- Т.Ганбат /ЗЗҮТҮСГ ахлах мэргэжилтэн/
- А.Болортуяа РДЗХГ Радио давтамж
хуваарилалт, бүртгэлийн мэргэжилтэн/

Харилцаа холбооны зохицуулах хорооны
даргын 2019 оны 04 сарын 07 өдрийн
А/82 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

АВЛАГА БАРАГДУУЛАХ, ШИЙДВЭРЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Зорилго, үндэслэл:

Дотоод аудитын хяналт, үзлэг шинжилгээ хийж, бүртгэгдсэн авлагын үүссэн шалтгаан, нөхцөл байдлыг холбогдох шийдвэр, баримт бичиг, материалд нь үндэслэн тогтоож зөвшөөрөл тус бүрээр нь тодорхойлолт хийж магадлагаа гаргаж шийдвэрлүүлэх.

Хамрах хүрээ:

ХХЗХорооны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн цуцлагдсан, дууссан төлөвтэй зөвшөөрлийн хуримтлагдсан авлагын хэсэг.

Хугацаа

2019 оны 4 дүгээр сар 1-ний өдрөөс 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдөр дуустал

№	Хийгдэх ажлын хамрах хүрээ	Хариуцсан мэргэжилтэн	Хяналт	Хугацаа
1	Өр төлбөртэй зөвшөөрлийн жагсаалтыг гаргаж 2019 оны барагдуулалтыг тайлагнан зөвшөөрлийн тоо болон өр төлбөрийн дүнгээр авлагын дүнг тодорхой болгох	Д.Гантуяа, Э.Эрдэнэбаяр	Н.Халиунаа	2019/04/5- 2019/04/10
2	Харилцагч тус бүрээр /зөвшөөрөл тус бүрээр/ төлбөр тооцооны дэлгэрэнгүйг он оноор түүхчлэн гаргах	Д.Гантуяа, Э.Эрдэнэбаяр	Н.Халиунаа	График гарган тогтмол
3	Зөвшөөрөл тус бүрийн гэрээ гэрчилгээ материалыг архиваас олж бэлтгэх	Т.Түвшинбаяр М.Гантөмөр Б.Дэлгэрцэцэг Э.Эрдэнэбаяр	Ю.Баярбаатар З.Эрдэнэчулуун	График гарган тогтмол
4	Гэрээний дүн болон тарифын холбогдох шийдвэр, баримт, материалд нь үндэслэн тооцооны дэлгэрэнгүйгээс авлагын дүнг зөвшөөрөл тус бүрээр нь тогтоох /дахин үнэлэх/	Ц.Жаргалсайхан Н.Халиунаа Т.Ууганбат Т.Ганбат Ц.Бүрэнжаргал А.Болортуяа	З.Эрдэнэчулуун А.Эрдэнэбулаг Ю.Баярбаатар	График гарган тогтмол
5	Дахин үнэлсэн буюу тогтоосон зөрүүгийн актыг зөвшөөрөл тус бүрээр дэлгэрэнгүй үйлдэх	Ц.Жаргалсайхан Ц.Бүрэнжаргал	З.Эрдэнэчулуун А.Эрдэнэбулаг Ю.Баярбаатар	2019/05/5- 2019/05/15
6	Уг зөрүүг хянан нэгтгэж тайлан гаргаж хэрхэн шийдвэрлэх тухай магадалгаа гаргаж даргын зөвлөлд танилцуулах	З.Эрдэнэчулуун А.Эрдэнэбулаг Ю.Баярбаатар Д.Гантуяа		2019/05/15- 2019/05/25